2025 оны 6-р сарын 13

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ИРГЭДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛЖ, ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭХЭД АНХААРЧ БАЙНА



Баян-Өлгий аймгийн прокурорын газраас тус аймгийн Цагдаагийн газартай хамтран гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгоор "Хохирогчийн эрх-2025" арга хэмжээг эхлүүлжээ.

Тус аяны хүрээнд гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нөхөн төлүүлэх, арилгуулах, орчуулагч, хэлмэрч авах зэрэг хохирогчийн хуульд заасан эрхийг хангах, учирч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхийн зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагааны шуурхай байдал, үр дүнг сайжруулах зорилгоор мөрдөгч, прокурорууд сургалт зохион байгуулж, мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зэрэг тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

"Хохирогчийн эрх-2025" хамтарсан аян 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл үргэлжилнэ.